



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 323

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн яам, Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн 20,000,000.00 (хорин сая) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг Эрүүл мэндийн яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бямбадорж, Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн зохицуулагч Н.Цогзолмаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



0000635

Төрийн өмчийн бодлого, зохицуул
газрын 2019 оны 07 дугаар сарын 22-ний
323 дугаар тогтоолын ха



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХАРЬЯА ГЛОБАЛ САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ ДОХ, СҮРЬЕЭГИЙН ТӨСЛӨӨС ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ БА
ШИЛЖҮҮЛЭХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Тоо ширхэг	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Балансад шинэ үнэ үнэлүүлс төгрөг
1	Суудлын автомашин, Ниссан Патрол TD8, 07-24 УБГ, 555417	2005/2005	1	48,280,000.00	48,280,000.00	-	20,00
Нийт дүн				48,280,000.00	48,280,000.00	-	20,00
				(дөчин найман сая хоёр зуун наян мянган төгрөг)	(дөчин найман сая хоёр зуун наян мянган төгрөг)	-	(хорин